- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит ААТҮГ-ын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд

Баянхонгор тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит ААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит ААТҮГ-ын газрын 2019-2020 оны ногоон байгууламжийн үйл ажиллагаанд дотоод аудит 2020 оны 9-10 сард хяналт шалгалт хийж шалгалтын дүн эцэслэн гараагүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 1849620,8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 36992,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1893797.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 37875.9 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит ААТҮГ-ын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 15414838.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 7677331.3 мянган төгрөгөөр буюу 99.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	302,228.5	183,219.3	(119,009.2)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	6,266.5	10,135.0	3,868.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	295,962.0	173,084.3	(122,877.7)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,435,278.5	15,231,618.9	7,796,340.4
Үндсэн хөрөнгө	11,888,422.3	20,795,988.7	8,907,566.4
Хуримтлагдсан элэгдэл	(4,453,143.8)	(5,564,369.8)	(1,111,226.0)
Нийт хөрөнгө	7,737,506.9	15,414,838.2	7,677,331.3
Өр төлбөр	9,042.6	12,130.1	3,087.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,728,464.3	15,402,708.0	7,674,243.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,737,506.9	15,414,838.2	7,677,331.3

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл 10135.0 мянган төгрөг болж 3868.5 мянган төгрөгөөр өссөн нь “Гурван бүс паркийн, гандангийн цэцэрлэгт хүрээлэнгийн, Эрдэнэ мандал уулын, ногоон байгууламж, агуулахын зураг төсөв хийлгэхээр 9980,0 мянган төгрөгийг шилжүүлснээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2018 онд үүссэн 155,0 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна.

Баянхонгор тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит ААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа материалын дансны үлдэгдэл 173084,2 мянган төгрөг болж 122877,7 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал данснаас 37559,0 мянга, эм боох материалын данснаас 5000,0 мянга, барилгын засварын материал данснаас 9000,0 мянга, дуусаагүй үйлдвэрлэл данснаас 13818,0 мянга, бусад хангамжийн материал данснаас 56440,0 мянган төгрөгийг материалыг өмнөх оны үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 20795988,7 мянган төгрөг болж 8907566,4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 7000,0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 664407,4 мянган төгрөгийн нийт эзэмшлийн зам талбай, барилга, байгууламжийг шилжүүлэн авсан, сум дундын ойн ангиас балансаас баланст 533747,4 мянга төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан, байгууллагад эзэмшүүлсэн 4 газрыг үнэлж 7696300,0 мянган төгрөгийн бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь аймгийн ИТХ-н 2020.08.26-ний өдрийн 75 дугаар тогтоолоор 116738,6 мянга, 2020.01.21-ний өдрийн 121 дугаар тогтоолоор 379999,9 мянга, 2020.01.21-ний өдрийн 2 дугаар тогтоолоор 14802,1 мянга, 2020.09.14-ний өдрийн 89 дүгээр тогтоолоор 533747,4 мянга, сумын ИТХ-ын 2020.04.15-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор 62315,8 мянга, 2020.12.02 ний өдрийн 40 дүгээр тогтоолоор 85600,9 мянга, нийт 1198154,8 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан, дахин үнэлсэн 7696300,0 мянган төгрөгийн газар, өмнөх онд авлагаар үүсгэсэн 6111,4 мянган төгрөгийн зураг төсвийг орлого авсан, төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 7000,0 мянган төгрөгийг хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгийн данс шинээр үнэлгээнд хамруулсан 4 газрын үнэлгээ 7696300,0 төгрөгийн хөрөнгөөр өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 12130,1 мянган төгрөг болж 3087,4 мянган төгрөгөөр өссөн нь модны суулгац нийлүүлэх гэрээний дүнгээс дутуу шилжүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 15402709,0 мянган төгрөг болж 7674243,7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэлж бүртгэсэн газрын үнэлгээнээс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1870731.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 13594.3 мянган төгрөгөөр буюу 0,7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөвт байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 3446,9 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого өмнөх оноос нэмэгдсэнтэй, тусламж санхүүжилтийн орлого 17041,3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн хөгжлийн сангаас олгох санхүүжилт 23390,5 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал 1892787,7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 383797,7 мянган төгрөгөөр буюу 25,4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, байр ашиглалттай холбоотой зардал, хангамж бараа материалын зардал, норматив зардал, эд хогшил урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр, элэгдлийн зардал нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1088867,3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1088867,3 мянган төгрөгөөр, ажиллагсдын тоог 47 орон тоогоор тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 420294,6 мянган төгрөгөөр бууруулж 668572,7 мянган төгрөг, ажиллагсдын тоог 45 орон тоогоор баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 668572,7 мянган төсөв батлагдаж 1 удаа тодотгол хийн 640615,5 мянган төгрөгийн төсөв баталснаас 542191,4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 90424,1 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр, 8000,0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 542191,4 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс 90424,1 мянга, туслах үйл ажиллагааны орлогоор 6439,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 615562,0 мянган төгрөгийг зарцуулж 23492,4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 615562,0 мянган төгрөг буюу 96,1 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 22641,1 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 1099,0 мянга, хангамжийн материалын зардлыг 1702,6 мянга, цалингийн зардлыг 206,4 мянга, томилолтын зардлыг 500,0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээний 23492,4 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Төсвийн гүйцэтгэлийн бүлэгтэй тайлан

төгрөгөөр

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ХӨТӨЛБӨР 70417	640,615,500.00	615,562,029.45	25,053,470.55	96.09
АРГА ХЭМЖЭЭ 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	523,551,600.00	520,634,429.45	2,917,170.55	99.4
УРСГАЛ ЗАРДАЛ	523,551,600.00	520,634,429.45	2,917,170.55	99.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	523,551,600.00	520,634,429.45	2,917,170.55	99.4
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	321,951,900.00	321,745,491.66	206,408.34	99.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	46,544,300.00	46,544,300.00	0.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,876,200.00	57,876,160.00	40.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	23,542,800.00	21,840,113.79	1,702,686.21	92.8
Нормативт зардал	12,140,000.00	12,140,000.00	0.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	46,914,000.00	46,914,000.00	0.00	100.0
Томилолт, зочны зардал	500,000.00	0.00	500,000.00	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,582,400.00	2,074,364.00	508,036.00	
Бараа үйлчилгээний бусад зардал	11,500,000.00	11,500,000.00	0.00	100.0
АРГА ХЭМЖЭЭ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал				
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,263,900.00	15,260,700.00	3,200.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	15,263,900.00	15,260,700.00	3,200.00	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	6,940,700.00	6,940,700.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,323,200.00	8,320,000.00	3,200.00	100.0
АРГА ХЭМЖЭЭ 81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	101,800,000.00	79,666,900.00	22,133,100.00	78.3
УРСГАЛ ЗАРДАЛ	101,800,000.00	79,666,900.00	22,133,100.00	78.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	101,800,000.00	79,666,900.00	22,133,100.00	78.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,800,000.00	79,666,900.00	22,133,100.00	78.3

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Баянхонгор тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит ААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	86.9	1	86.9			
Зөвлөмж	2	544.0	2	544.0			
Нийт дүн	3	630.9	3	630.9			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 404156,9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 28865,0 мянган төгрөгийн алдааг залруулж, 375291,9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 22265,1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. /Хавсралт 1/

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант онд 14 нэр төрийн 150140,0 мянган төгрөгийн хөрөнгийн 24865,0 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг нягтлан бодогч дутуу тооцсон, бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 2 нэр төрлийн 4000,0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 28865,0 мянган төгрөгийн залруулга хийв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 375291,9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 353026,8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 22265,1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Тайлант онд тус байгууллагын дарга нар иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, цэцгийн үрсэлгээ, хөрс, бор шороо, давс, хайсны бэлдэц зэргийг худалдан авахаар 89499.1 мянган төгрөгийг шууд гэрээ байгуулж холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн байна.

- Баянхонгор сумын 4.5-р багийн нутаг дэвсгэрт замын засварын ажил хийлгэх гэрээ байгуулж ажил хийгдээгүй байхад, гэрээнд зааснаас өөр ажлын гүйцэтгэсэн гэж 2020.02.21-ны өдөр 8780.1 мянган төгрөгийг олгосон.

- Дээрх ажлуудыг хийлгэх урьдчилсан тооцоо судалгаа, төсөв гаргаагүй шууд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 14 ний өдрийн 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн захирагчид албан шаардлага хүргүүлж дээрх зөрчилтэй асуудлыг шалгаж цаашид хуулийн байгууллагад шилжүүлж зөрчлийг арилгах.

1. Байгууллагын даргын 2020.12.08 өдрийн 71 тоот тушаалаар томилогдсон тооллогын комисс нь тооллого явуулсан талаарх илтгэх хуудас бичсэн боловч тооллогыг хийсэн бүртгэл байхгүй, Баянхонгор сумын ИТХ-ын 2020.04.15 ний өдрийн 9 дүгээр тогтоол, эзэмшүүлэхээр шилжүүлсэн хөрөнгөөс 93086,9 мянга, 2020.12.04 өдрийн 40 дүгээр тогтоолоор эзэмшүүлсэн хөрөнгөөс 161660,7 мянга нийт 254747.6 мянган төгрөгийн 4 нэр төрлийн хөрөнгийн орлого аваагүй байхад энэ талаар анхаарч үзээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон

Баянхонгор тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит ААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Оршин байх”, “Үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын өмч хөрөнгийн тооллогыг 2021.05.10-ны дотор хийж баталгаажуулан зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.Тайлант хугацаанд “Шилэн дансны тухай” хуулийн дагуу байршуулбал зохих мэдээллээс өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан, хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайланг байршуулаагүй. төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, хөрөнгийн зардал, бонд, зээл, өрийн бичиг, концессын зүйлийн жагсаалт, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, хагас жилийн санхүүгийн тайлан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 151736,7 мянган, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 6140,0 мянган төгрөгийн 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээлээгүй мэдээллийг нөхөж мэдээлэх цаашид хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага өгөв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 22265,1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба тус байгууллагын 2019-2020 оны үйл ажиллагаанд аудитыг хийсэн ба шалгалтын дүн эцэслэгдэн гараагүй байна.

Иймээс тус байгууллагын нэмэлт хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, ногоон байгууламжийн зардлыг аудитаар хамруулан шалгаагүй олгосон санхүүжилт, байгуулсан гэрээг харьцуулан үзсэн болно.

Тайлант онд ногоон байгууламж нэмэгдүүлэх, тохижилт, завсар үйлчилгээг хийх ажлын төлөвлөгөө, төсөв гаргахгүй хувь хүн, ААНБ-уудтай гэрээ байгуулан нэг төрлийн ажил үйлчилгээг хувааж гэрээ байгуулсан, гэрээний хэрэгжилтийг тооцоогүй, бараа материалын данснаас ашиглагдаж байгаа завсрын материалыг их хэмжээгээр анхан шатны баримтгүй зарлагдсан, 12140,0 мянган төгрөгийн нормын хувцас худалдан ажилчид хүлээлгэж өгсөн бүртгэл байхгүй, зарлага гаргасан, байгууллагын ойн арга хэмжээний хүрээнд ажиллагсдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 7490,0 мянган төгрөгийг төсвөөс зарцуулсан атлаа олгосон жагсаалт байхгүй, ажиллагсдын орон сууцны барилга баригдаагүй байхад техник хяналтын зардалд 4000,0 мянган төгрөгийг төсвөөс ГХБХБГ-т төлсөн, ногоон байгууламж, замын халтиргаа гулгаа арилгах ажилд зарцуулагдаж байгаа хөрөнгөд хяналт тавьдаггүй, зарцуулалтын тооцоо, тайлан байхгүй шууд зарлага гаргасан зөрчлийг дараагийн аудитаар анхаарч үзэх.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1.Илрүүлэлт: Тайлант онд аймгийн Засаг даргын 2019.05.3-ний өдрийн А/303 тоот захирамжаар тус байгууллагын эзэмшилд шилжүүлсэн Жаргалант парк, Гурван бус цогцолбор, Мазаалай цэцэрлэгт хүрээлэн, ахмадын садны газрын үнэлгээг, байгууллагаас томилогдсон ажлын хэсэг хийж 7696300.0 мянган төгрөгөөр үнэлж мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй санхүүгийн тусгасан нь Сангийн сайдын 2018 оны 8 дугаар сарын 7 ний өдрийн “аргачлал батлах тухай” 207 тоот тушаалын 10 дугаар хавсралтын дагуу үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нягтлан шалгалтын тайлан гаргуулж дүгнэлт гаргуулаагүй байна.

1.2.Эрсдэл: Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

1.3.Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2018 оны 08 дугаар 08 ний өдрийн 207 тоот тушаалын 10 дугаар хавсралтын дагуу дүгнэлт гаргуулах, цаашид хөрөнгийн дахин үнэлгээг хийлгэхдээ журмыг баримталж ажиллан, хараат бус мэргэшсэн үнэлгээчний дүгнэлт гаргуулж байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Өглөг авлагын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: “Оюунлаг хонгорчууд” НҮТББ-тай модны суулгац худалдан авах 45500,0 мянган төгрөгийн гэрээг 2020.05.23 ний өдөр байгуулж, гүйцэтгэлээр 33486.9 мянган төгрөгийг олгосон ба гэрээний хэрэгжилтийг дүгнэж тооцоогүйгээс 12013,1 мянган төгрөгийн өглөгийг нягтлан бодогч тайланд тусгасан энэ нь тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайланд тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудад зөрчсөн байна.

2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зөвшөөрөлгүй зориулалт бусаар зарцуулсан байх.

2.3.Өгсөн зөвлөмж: “Оюунлаг хонгорчууд” НҮТББ-ын 2020 онд гүйцэтгэсэн ажлыг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлэн, гэрээг дүгнэж тооцоо хийж баталгаажуулах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

3.1.Илрүүлэлт: Өмнөх оны ажилдагсадтай холбоотой 155.0 мянган төгрөгийн авлага, 117.0 мянган төгрөгийн өглөг барагдуулаагүй, “ЦЭСДА” ХХК-аар “Гурван бүс паркийн, гандангийн цэцэрлэгт хүрээлэн, эрдэнэ мандал уулын ногоон байгууламж, байгууллагад агуулах барих зураг төсөв хийлгэх гэрээ байгуулан 9980.0 мянган төгрөгийг 2020 оны 6 сард шилжүүлж тухайн зураг төсвийг хийлгээгүй, харин ажилчдын орон сууцны зураг төсвийг хийлгэж өмнөх оны авлагыг хааж тухайн шилжүүлсэн мөнгийг авлагаар бүртгэж тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

3.2.Эрсдэл: төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах, чанаргүй өглөг авлага үүсэх эрсдэлтэй

3.3.Өгсөн зөвлөмж: Өмнөх оны авлага, өглөгийн тооцоог нийлж, тайлант онд “ЦЭСДА” ХХК олгосон 9980,0 мянган төгрөгийг ажлыг гүйцэтгээгүй тул байгууллагын дансанд буцаан татан авч, цаашид хөтөлбөр арга хэмжээг

Баянхонгор тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит ААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит хэрэгжүүлэх санхүүжилт батлагдаагүй байхад төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулж авлага үүсгэдэг явдлыг таслан зогсоож, ажлыг гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР

Г.ГАНЧИМЭГ 2021.02.24

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.02.24

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.02.24



**Баянхонгор тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит ААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баянхонгор тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит ААТҮГ-ын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
2020			БНА-2021/71/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит ААТҮГ-ын газар	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	-Тайлант онд тус байгууллагын дарга нар иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, цэцгийн үрсэлгээ, хөрс, бор шороо, давс, хайсны бэлдэц зэргийг худалдан авахаар 89499.1 мянган төгрөгийг шууд гэрээ байгуулж холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн байна. - Баянхонгор сумын 4.5-р багийн нутаг дэвсгэрт замын засварын ажил хийлгэх гэрээ байгуулж ажил хийгдээгүй байхад, гэрээнд зааснаас өөр ажлын гүйцэтгэсэн гэж 2020.02.21-ны өдөр 8780.1 мянган төгрөгийг олгосон.	98279.2	Албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Т.Отгонбаатар, Б.Болормаа
2	Байгууллагын даргын 2020.12.08 өдрийн 71 тоот тушаалаар тооллогын комисс тооллогын ажлыг зохион байгуулсан илтгэх хуудас бичсэн боловч тооллогыг хийсэн бүртгэл байхгүй, Баянхонгор сумын ИТХ-ын тогтоолоор эзэмшүүлсэн хөрөнгөөс 254747.6 мянган төгрөгийн 4 нэр төрлийн хөрөнгийн орлого аваагүй байна.	254747.6	Албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Т.Отгонбаатар, Б.Болормаа
3	"Шилэн дансны тухай" хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээлэл оруулахаас 2 мэдээллийг байршуулаагүй, 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн Үүнээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 151736.7 мянга, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 6140.0 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн.	-	Албан шаардлага өгөх	Дарга, Нягтлан бодогч	Т.Отгонбаатар, Б.Болормаа
4	Байгууллагаас томилогдсон ажлын хэсэг "Жаргалант парк, Гурван бус цогцолбор, Мазаалай цэцэрлэгт хүрээлэн, ахмадын садны газрын үнэлгээг хийж 7696300.0 мянган төгрөгөөр үнэлж мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй санхүүгийн тусгасан.	0	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	Т.Отгонбаатар, Б.Болормаа
5	"Оюунлаг хонгорчууд" НҮТББ-тай модны суулгац худалдан авах 45500,0 мянган төгрөгийн гэрээг 2020.05.23 ний өдөр байгуулж, гүйцэтгэлээр 33486.9 мянган төгрөгийг олгож гэрээний хэрэгжилтийг дүгнэж тооцоогүй, бэлтгэн нийлүүлэгчтэй 12013.1 мянган төгрөгийн өглөг баталгаажуулаагүй тайланд тусгасан.	12013.1	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	Т.Отгонбаатар, Б.Болормаа
6	Өмнөх оны ажилдагсадтай холбоотой 155.0 мянган төгрөгийн авлага, 117.0 мянган төгрөгийн өглөг барагдуулаагүй, "ЦЭСДА" ХХК-аар "Гурван бус паркийн, гандангийн цэцэрлэгт хүрээлэн, эрдэнэ мандал уулын ногоон байгууламж, байгууллагад агуулах барих зураг төсөв хийлгэх гэрээ байгуулан 9980.0 мянган төгрөгийг 2020 оны 6 сард шилжүүлж тухайн зураг төсвийг хийлгээгүй, харин ажилчдын орон сууцны зураг төсвийг хийлгэж өмнөх оны авлагыг хааж тухайн шилжүүлсэн мөнгийг авлагаар бүртгэж тооцоо нийлж баталгаажуулаагүй.	10,252.0	Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	Т.Отгонбаатар, Б.Болормаа
7	Тайлант онд 14 нэр төрийн 150140,0 мянган төгрөгийн хөрөнгийн 24865,0 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг нягтлан бодогч дутуу тооцсон, бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 2 нэр төрлийн 4000,0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.	28865.0	Санхүүгийн тайланд залруулга хийсэн	Дарга, Нягтлан бодогч	Т.Отгонбаатар, Б.Болормаа
Дүн		404156.9			

ооо